

МОНГОЛЧУУДЫН СЭТГЭЛГЭЭН ДЭХ БАЙГАЛИЙН ГОО САЙХНЫ ТУХАЙ ҮЗЭЛ ЭКОЛОГИЙН АЧ ХОЛБОГДОЛТОЙ БОЛОХ НЬ

П.Мягмарсайхан

ШУА-ийн Философийн хүрээлэн

Б.Мөнхжавхлан

МУИС, Философи, шашин судлалын тэнхимийн ахлах багш, PhD

Товч агуулга: *Гоо сайхны үзэл бол оршин буй юмс үзэгдэлтэй хүмүүсийн харилцаж буй харилцаа болон илэрхийлж буй хэлбэр байдаг. Монголчуудын хувьд оршин буй бүхнээ байгаагаар хайрлан хамгаалах уламжлалыг олон арван жилээр тээж ирсэн ба үүнтэйгээ уялдаж байгальд хандах гоо сайхны үзэл нь хайрлан бишрэх, унаган төрхийг алдагдуулахгүй байх, байгаль дэлхийгээ эрхэм дээд үнэт зүйл болгон дээдлэж ирснээр илэрдэг. Энэ нь гоо зүйн үнэлэмж болохын сацуу байгалийг хамгаалах, экологийн бодлогод үлэмж нөлөөтэй байж иржээ. Энэхүү өгүүлэлд монголчуудын амьдралын онцлог, байгальтай харилцах уламжлал, ардын мэдлэг ухаанд туссан байгалийн гоо сайхны үзэл нь уламжлалт гоо зүй болон орчин үеийн энвайронменталь гоо зүйн үзлийн аль алиныг шингээсэн агуулгатай болохыг харуулав.*

Түлхүүр үг: *уламжлал, байгаль, гоо сайхан, бишрэл хүндэтгэл, байгалийн тэнцвэрт байдал, үнэлэмж, хүрээлэн буй орчны буюу энвайронменталь гоо зүй.*

Энэ өгүүлэлд зохиогчид монголчуудын оюун сэтгэлгээ, ахуй амьдралын салшгүй хэсэг болсон байгаль дэлхийгээ хэрхэн үнэлж, түүнээ гоо сайхны үнэлэмжээ болгож тогтоож ирсэний олон зууны туршид байгалийг унаган дагшин хэвээр хадгалж ирэхэд нөлөөлсөн болох, тус үнэлэмж нь орчин үеийн гоо зүйн сэтгэлгээний чухал нэг талбар энвайронменталь гоо зүйн агуулгатай нийцэж байгааг харуулахыг зорьсон. Энэ үүднээс нэгдүгээрт: энвайронменталь гоо зүйн үзэл баримтлалын агуулга, онцлог нь байгаль орчныг хамгаалах, хадгалах онолын эх сурвалж гэдгийг тодруулах, хоёрдугаарт: монголчуудын байгалийн гоо сайхны тухай үзэл хэрхэн нүүдэлчин соёлтой холбоотой боловсорсон хийгээд түүнийгээ урлагийн зарим төрлүүдэд тусгасан байдал, гуравдугаарт: гоо сайхны үзлийн экологийн ач холбогдол гэсэн агуулгын хүрээнд шинжилгээ хийв.

Байгаль бол хүний оршин амьдрах гол ахуй, танин мэдэхүйн чухал объект бөгөөд хүрээлэн буй орчны (энвайронменталь) философи, үнэлэмж, ёс

зүй, гоо зүйн мэдлэгийн салбарыг хамарсан өргөн агуулгатай байна.

Энвайронменталь

үзэл

баримтлалын тухай: Орчин үед шинээр бий болсон энвайронменталь гоо зүйн үзэлд байгалийн гоо сайхны үнэлэмжийн талаарх ялгаатай үзэл баримтлал, байгалийн тухай бичвэр, байгалийг нөөцлөн хамгаалах талаар судалдаг. Ингэхдээ гоо зүйн философи онол, туршлагын тухай зарим асуудлуудыг тодруулахыг зорьж байдаг. Тухайлбал урлагийн туршлага, байгалийн гоо сайхны туршлага буюу мэдрэхүйн таашаал, мэдрэмж ялгаатай эсэх, байгальтай харилцах гоо зүйн харилцаа, төсөөлөл, байгалийн талаарх гоо зүйн үнэлэмж, байгалийн тухай урлагийг авч үздэг.

Энэ талаар судлаач Рональд Хэпбюрны 1966 онд бичсэн “Contemporary Aesthetics and the Neglect of Natural Beauty” өгүүлэл ихээхэн алдартай бөгөөд тэрбээр дараах санааг илэрхийлсэн байна. Нэгдүгээрт, байгальтай харилцах гоо зүйн харилцаанд хүн байгальд оршихын

сацуу түүний нэг хэсэг болохын хувьдаа тэрнийхээ дүр болоод үзэгч нь болж байдаг. Хоёрдугаарт, урлагийн бүтээлээс ялгаатай нь байгалийн зүйл гоо зүйн объект болохын тухайд хүрээлэн буй орчноос ангид байдаггүй. Тэдгээр нь “жааз хүрээ-гүй” байдаг. Гуравдугаарт, байгалийн талаарх гоо зүйн туршлага нь тайлбарлагдаагүй өнгө, дүрс, хээ хуар, хөдөлгөөний талаарх бодрол бясалгалаар хязгаарлагдах ёсгүй. Эцэст нь, байгалийн юмсын харагдах байдлыг хариуцдаг эсвэл байгалийн үзэгдэлд идэвхтэй оролцдог хүч, үйл явцыг төсөөлөн бодох нь байгалийн гоо зүйн туршлагын үндсэн үйл ажиллагаа юм¹ гэсэн байдаг. Эндээс харвал энвайронменталь гоо зүйн үзэл байгаль, түүнтэй харилцах харилцаа гоо зүйн талаас объектыг эсвэл субъектын мэдрэмжийн туршлагыг онцолсон өргөн агуулгатай мэдлэгийн төрөл юм.

Эр тнээс нааш с айх ан болон байгалийн тухай асуудлыг Гераклит, Платон, Аристотель, Фома Аквины нарын олон философичид авч үзэж байв. Улмаар Гегель, Кант, Шеллинг нар судалж, хожим Жозеф Эддисон (1672-1719), Александр Готлиб Баумгартен (1714-1762) Энтони Ашли Күүпер (1801-1885) Теодор Адорно (1903-1969) нар гоо зүйн шинэ үзэл баримтлал болгон хөгжүүлсэн юм. Тэд байгалийг бие даасан гоо зүйн туршлага, үнэлэмжийн объект хэмээн үзсэнээрээ байгалиас илүүтэй харин түүнийг илэрхийлдэг урлагт анхаарал хандуулдаг байсан өмнөх үеийнхнээс ялгарч байв.² Түүний сацуу гоо зүйн үнэлэмжийн категорийг “сүрлэг”, “сэтгэл татам” гэдэг ойлголтуудаар өргөжүүлжээ. Өмнөх үеийн сэтгэлгээ гоо зүйн объект, түүнийг таашаан хүлээн авагч хоёрын харилцааг ойлгох сайхны чанарын тухайд анхаарал хандуулдаг байсан бол хожим гоо зүйн туршлагын шинж, таашаах, мэдрэх гэдэгт илүү чиглэх болжээ. Байгалийн буюу

объектын харагдах байдал өмнөх үед онгон зэрлэг байгаль сайхан, сүрлэг гэдэг гоо зүйн чанараараа таашаагдахаас илүүтэй айдас төрүүлдэг байв. XVII зуун хүртэл хүний гар хүрсэн буюу хүний бүтээсэн, өөрчилсөн байгаль, эсвэл урлаг, утга зохиол, бүтээлээр илэрч байгаа байгалийн тухай дүрслэлийг хүндэтгэн хүлээж авах нь нийтлэг байжээ. Энэ нь ч орчноо тохижуулах, цэцэрлэгжүүлэх урлаг, онолын суурь, туршлага нь болж байв (Landscape theory). XVIII зуунаас байгальд хандах гоо зүйн үзэл санаа өөрчлөгдсөн бөгөөд энд И.Кантын нөлөө их бий. Кант урлагаас байгалийг илүүд үздэг байсан бөгөөд гоо зүйн онолын үүднээс байгалийн гоо зүйн үнэлэмж нь хүний амьдралд илүү чухал, тэр ч байтугай ёс суртахууны хувьд илүү боловсронгуй болоход тусладаг гэж байв. Байгалийг ийнхүү үзсэн нь сайхан, сүрлэг гэдэг ойлголтуудыг хэрхэн ойлгохтой холбоотой юм. Тэрээр сайхан бол сэтгэл татам, тааламжтай мэдрэхүйн чанар, тайван байдалтай холбоотой, харин сүрлэг гэдэг нь асар том, хүчирхэг, хүчирхэг зүйлд дарагдсан мэдрэмжийг мэдрэх “сөрөг таашаал”-тай холбоотой гэж үздэг. Цавчим өндөр хад асга, хүчтэй давалгаалах далай тэнгис, асар уудам цөл зэрэг байгалийн үзэгдлийн хязгааргүй мэт санагдах байдлыг үүгээр жишээлж болно. Байгалийн тухай бодролууд хүнд өөрийг нь өчүүхэн мэт мэдрэмжийг төрүүлдэг ч дэлхий дээрх эрх чөлөөтэй, ёс суртахуунтай, ухаалаг амьтан гэдгээ бас ухаарахад нөлөөлж байдаг гэж тэрээр үзэж байжээ.

Кант “Дүгнэн бодохуйн шүүмж” номондоо “Байгалийн сайхныг мэдрэх нь сайн хүний шинж” хэмээгээд түүнийхээр нар жаргах эсвэл наран шарлагын газар хамтдаа сайхныг мэдрэх нь бид бүгдийн болоод орчлон ертөнцийн найрс ал зохицлын учир юм. Энэ талаараа цэвэр гоо үзэсгэлэнгийн тухайд дүгнэн бодохуй нь хувиа үл хичээх ёс суртахууны үзэл санаанд

¹ Jerrold Levinson. *The Oxford Handbook of Aesthetics* (Oxford Handbooks Series). 2005., p.160

² J.Baird Callicot, Robert Frodeman. *Encyclopedia of environmental ethics and philosophy*. 2009., p.314

хүрдэг билээ³ гэсэн нь бий. Кантын эл үзэл баримтлал романтизм болон XIX зууны уран зохиол, яруу найраг, хөгжим, дүрслэх урлагаар илэрхийлэгдсэн “байгалийг шүтэх” үзэлд нөлөөлсөн юм.

Гегель байгалийн талаар гоо зүйн чухал үзэл баримтлалыг боловсруулсан. Түүнийхээр байгалийн гоо зүйн үнэлэмж зөвхөн урлагийг бүтээх замаар хүний оюун санаагаар бий болсон үед л бодитой болдог. Тэрбээр урлагийн тухай ойлголтыг байгалийн репрезентацаас өөрөөр хүний төсөөллийн илэрхийлэл гэсэн утгад шилжүүлс эн нь илүү хийсвэрлэс эн шинжтэй болсон байна. Энэ утга түүний философи дахь туйлын оюун санааны проекц юм. Ингэснээрээ Гегелийн үзэлд урлаг ертөнцийг натуралист өнгө аясаар дүрслэхээс илүү илэрхийлэл, хийсвэрлэл рүү шилжсэн байдаг. Харин Т.Адорно “Гоо зүйн онол” бүтээлдээ Шеллингийн философийг тухай дурдахдаа “...түүний философийн үеэс гоо зүйн сонирхол урлагийн бүтээл дээр төвлөрөх болжээ. “Дүгнэн бодохуйн шүүмж”-ийн хамгийн гүн ойлголтуудын үндэс байсаар ирсэн байгалийн гоо үзэсгэлэн нь одоо онолын эд эв болж чадахгүй байна. Үүний шалтгаан нь Гегелийн онолын дэвшүүлсэн шиг байгалийн гоо үзэсгэлэн диалектикийн хувьд давж, үгүйсгэгдэж, илүү өндөр түвшинд хадгалагдаж байсанд биш, харин дарагдаж байснаас болжээ. Иймээс байгалийн гоо сайхны тухай эргэцүүлэн бодох нь урлагийн онолд зайлшгүй хэр эгтэй юм”⁴ гэжээ. Энэ санаагаар тэрээр баталгаажуулж байгалийг гоо зүйн үүднээс авч үзэх үзэл баримтлалаа дэвшүүлсэн байдаг. Романтизмын нөлөө багассанаар байгалиас холдож буй байдал урлагийн ертөнцийн хөгжилд ч илэрхий байв. XX зууны авангард сэтгэлгээ философичдод байгалиас илүү урлагт анхаарлаа хандуулахад илүү их урам зориг өгсөн. Гэхдээ Жон Муир (1838–1914), Алдо Леопольд (1887–1948) нарын

энвайронменталистууд экологийн мэдлэг, гоо зүйн мэдрэмжийн тухай ойлголтыг нэгтгэж байгалийн үнэлэмжийг зөвхөн үзэсгэлэнтэй сайхан гэдгээр хязгаарлалгүй улам бүр нэмэгдүүлэхийг зорьсон нь энвайронменталист гоо зүйн эхлэл төдийгүй зорилго болсон юм. Хүний гар хүрээгүй зэрлэг онгон байдлыг байгалийн гоо үзэсгэлэн гэж үзэхийн зэрэгцээ орчноо тохижуулах, цэцэрлэгжүүлэх урлаг, мөн байгалийг хамгаалахтай холбоотой утга зохиол хөгжиж эдгээр нь энвайронменталь гоо зүйн түүхэн үндэс болсон байдаг. Энвайронменталь гоо зүй судлаач Арнольд Берлеант гоо зүй нь урлагаас илүүтэй байгалийг судлах ёстой гээд, гоо зүйн туршлага нь хүний гараар бүтээгдсэн болон онгон зэрлэг байгаль аль аль нь урлагт тусгагдах учиртай гэж байв. Улмаар хүрээлэн буй орчинд оролцох объект, субъектын дихотомийг оролцооны гоо зүй гэсэн ойлголтоор сольсон ажээ. Ийнхүү философичид, энвайронменталист сэтгэгчид урлагийн философи болон энвайронменталь гоо зүйн ялгааг тодруулж уламжлалт гоо зүйн үзэлд байсан явцуу, статик, хоёр хэмжээст үнэлэмжийг цаг хугацаа, цаг агаарын байдал, улирал зэрэг бүгдийг оролцуулсан, ажиглан мэдрэгчийн мэдрэмжийг онцолсон гурван хэмжээст болгон хөгжүүлсэн байдаг.

Экологийн тухай мэдлэг, ойлголт хүн байгалийг өнгөцхөн үнэлэмжээс илүү өргөн хараагаар харахад нөлөөлдөг бөгөөд ёс суртахууны болон гоо зүйн амьдрал, үнэлэмжид чухал ач холбогдолтой байдаг. Гоо зүйн үнэлэмж бол инструменталь бус шинжтэй, иймд “дахин бүтээхүй” зэрэг энвайронменталь таашаалаас ангид байх ёстой юм. Энвайронменталь гоо зүйн гол зорилго бол гоо зүйн үнэлэмжийн талаар философи үндэслэл бүхий ойлголт, үзэл санааг бий болгох явдал юм. Энвайронменталь гоо зүй нь мэдрэмж, төсөөлөлд суурилсан идэвхтэй ойлголтоор дамжуулан хүрээлэн буй

³ Barry Hartley Slater. 'Aesthetics', The Internet Encyclopedia of Philosophy. <http://www.iep.utm.edu> (2006)

⁴ Theodor Adorno, Aesthetic Theory. 2002. p.61-62

орчинтойгоо харилцахдаа гоо зүйн туршлага олж авах арга замыг судалж байдаг. Тиймээс энвайронменталь гоо зүй нь байгаль, барилга байгууламж, хотын орчин, ахуйн орон зай, тэдгээр доторх янз бүрийн объект, бусадтай харилцах харилцааны хувьд олон талт шинжтэй байдаг. Энэ утгаар бид гоо зүйн болоод ёс суртахууны өргөн хүрээнд байгалийг ухаарч, тайлбарлаж, ойлгож байдаг. Хүн оршиж, аж төрж буй ертөнцтэйгөө нарийн холбоотой амьдрахын зэрэгцээ байгаль бас бидний амьдралын чанарт нөлөөлж байдаг тул энвайронменталь гоо зүй хүрээлэн буй орчинтой харилцах ойр дотно харилцаа холбоог ийнхүү өвөрмөц замаар судалж байдаг. Орчин үед судлаачид, энвайронменталистуудын үзэлд энэхүү үзэл баримтлалуудыг уялдуулж авч үзэж буй хандлага ихээхэн илрэх болсон. Шинээр гарч ирж буй хувьсал-экологийн ертөнцийг үзэх үзлийн хүрээнд гоо зүй, ёс суртахууны үнэлэмжийг сайтар тусгаж, өөрчлөх нь XXI зуунд байгаль хамгаалахад нэн чухал билээ.”⁵ Эндээс харвал гоо зүйн үнэлэмж таашаан бахархах, хүндэтгэхээс илүү өргөн ач холбогдлыг өөртөө тээж байна. Тухайлбал Шейла Линтон, Эллен Карлсон нар “байгалийг нөөцлөн хамгаалахтай холбоотой шийдвэрүүд ёс зүйн үнэлэмжээс илүү гоо зүйн үнэлэмж дээр суурилж гардаг”⁶ гэж үзсэн нь бий. Энэ үзэл санаанд нийцэх баримт бидний нийгмийн амьдралаас ихээхэн гарч ирэх нь зайлшгүй.

Монголчуудын соёл, сэтгэлгээн дэх байгалийн талаарх үнэлэмжийн тухай: Сайхны тухай ойлголт нь үндэсний өвөрмөц онцлог, хүн ардынх нь сэтгэлгээний илрэл болж байдаг. Хүн танин мэдэж, ойлгож ухаарсан зүйлээсээ сайхныг олж хардаг тул түүний танин мэдэхүй, үнэлэмжийн чухал нэг хэсгийг байгалийн тухай мэдлэг эзэлнэ. Ер нь сайхны тухай ойлголт эрин цаг үе бүрт өөрчлөгдөж ирсэн байдгийн дотор байгалийн гоо сайхан нь

хүмүүсийн ердийн үзэл санаанд харьцангуй тогтвортой хэвээр үлдсэн байдаг. Харин байгалийн гоо сайхныг хадгалж хамгаалах хүний үйлдэл, ёс суртахуунд өөрчлөлт гарсан байдаг. Хүн төрөлхтөн байгалиас баялагийг нь уудлан авахын зэрэгцээ байгалийн гоо сайхнаар цэнгэж баясаж, бүтээл туурвилынхаа онгод, санааг олж авсан байдаг.

Монголчуудын сэтгэлгээн дэх байгаль хандлага, үнэлэмж, онцлогийн талаар судлаачид төсөөтэй дүгнэлтүүдийг судалгааны үр дүнд тэмдэглэсэн байдаг. Судлаач Ж.Төмөрбаат ар монгол хүмүүсийн байгалийн сайхныг үнэлэх үнэлгээнд хоёр гол баримтлал бүрэлдэжээ гэсэн. Нэгдүгээрт байгалийн үзэгдэл үйл явцын зүй зохистой зохилдолгоот холбоо буюу, хослол жигдрэл, үзэмж төгөлдөр байдлыг байгалийн сайхан гэж үнэлж байна. Хоёрдох нь гайхамшигтай зүйл гэдэг гоо сайхны бас нэг чухал ойлголт давхцан илэрхийлэгдэж байгааг анхаарах хэрэгтэй⁷ гэжээ.

Монголын философийн түүхийн I дэвтэрт эртний монголчуудын гоо сайхны сэтгэлгээний тухай мөн авч үзсэн байдаг. Энд “Монголчуудын гоо сайхны сэтгэлгээ нь олон зууны турш эрхэлж ирсэн ахуйн хэвшил, нүүдлийн мал аж ахуй, түүнийг дагалдан төлөвшиж тогтсон хүмүүсийн амьдралын хэв маяг болох нүүдэлчин амьдралт ай юуны өмнө холбоотой. Чингэхд ээ хүмүүс хооронд болон хүрээлэн буй байгаль орчинтой харилцах харилцаанаас”⁸ гоо сайхны сэтгэлгээний онцлогийг нөхцөлдүүлсэн хэмээн үзжээ. Энэ бүтээлд эрт үеийн гоо сайхны сэтгэлгээ нь домогт үндэслэж байсныг дурдаад аливаа дүрслэлд нь араатан амьтны аюулыг дүрсэлсэн байдаг ба энэ нь ид шидийн талаас нь ханддагт оршино гэжээ. Эртний монголчуудын зураг дүрслэл, хадны сүг зурагт уугуул нутгийнхаа өвөрмөц

⁵ R. Rozzi et al. (eds.), Linking Ecology and Ethics for a Changing World: Values, Philosophy, and Action. 2013, p.109

⁷ Ж.Төмөрбаатар. Монголын ард түмний гоо сайхны сэтгэлгээний түүхийн асуудал. УБ.,1990. 22 дахь тал.

⁸ Монголын философийн түүх. I дэвтэр. УБ.,1997, 171 дэх тал.

⁶ Also see. p.112

⁷ Ж.Төмөрбаатар. Монголын ард түмний гоо сайхны сэтгэлгээний түүхийн асуудал. УБ.,1990. 22 дахь тал.

⁸ Монголын философийн түүх. I дэвтэр. УБ.,1997, 171 дэх тал.

шинж онцлогийг тусгасан, ан амьтныг дүрсэлснийг дээрх бүтээлд авч үзэхдээ амьтныг танин мэднэ гэдэг бол хүрээлэнбуй орчин бодит ертөнцийг танин мэдэхухаан гэж үзэж болно гэжээ.

Монголчууд өөрсдийгөө байгалиас ангид авч үздэггүй. Учир нь монголчууд олон зууны туршид байгаль, газар нутгийн онцлогтоо тохирсон аж ахуй эрхлэн, байгальтайгаа хүндэтгэлтэй харьцаж, байгалиа шүтэж, дээдэлж, нэгдэж, оршин тогтнож буй бүхнийг байгалийн жам хуулийн дагууд нь ойлгож ирсэн байдаг. Тийм ч учраас гоо сайхны сэтгэлгээний хувьд байгалийн сүр хүч, төгс төгөлдөр, сайхан бүхнийг өдөр тутмын амьдралынхаа явцад харж, мэдэрч, шүтэж, хайрлаж, биширч энэ бүхнийгээ ардын аман зохиол, үлгэр домог, ертөнцийн гурав, оньсого, зүйр цэцэн үгс, ерөөл магтаал, дом шившлэг, зураг урлал, уртын дуу зэрэгтээ дүрсэлсэн байдаг билээ. Монгол мэргэдийн бүтээл туурвил, шүлэг яруу найраг, уран бүтээлүүдэд ч байгалийн гоо сайхны илэрхийлэл олонтаа туссан байдаг. Жишээлбэл, уламжлалт магтаалд тухайн уул усны ганган байдлыг дөрвөн улирлын үзэмжийг тооцон дүрсэлж магтах нь ч буй. «Сайхан хан уулын магтаал», «Ээжийн нуурын магтаал», «Онгон уулын магтаал», «Жавхлант хонгорын магтаал», «Алтан Хянганы магтаал», «Хөлөн буйрын магтаал», «Шар мөрний магтаал», «Далан харын магтаал», «Баян Ганьдарийн магтаал», «Уран дөшийн магтаал», «Хатан далайн магтаал», «Алшан хайрханы магтаал», «Тэнгэр элсний магтаал», «Үүшинзуугийн магтаал», «Тэнгэр уулын магтаал», «Баян булгийн магтаал», «Алтайн магтаал»⁹ гэх мэтээр яруу сайхнаар дүрслэн, нүдээр хараагүй нэгэнд нүдэнд харагдтал нь дүрсэлдэг байсан нь монголчуудын байгалийн гоо сайхны үнэлэмжийг илтгэж байна. Бас уудам тал, сүрлэг уул усаа биширч, буянт

мал сүргээ хайрлан бахдахдаа дуулж ирсэн уртын дуундаа байгалийн сайхныг шингээн урласан байдаг. Тухайлбал “Зээргэнэтийн шил” гэдэг уртын дуу монголчуудын дунд 800 гаруй жил, “Түмний эх” уртын дуу нь 300 орчим жил¹⁰ дуулагдаж ирсэн байна. Мөн “Уяхан замбивийн нар”, “Тэнгэрийн салхи”, “Дөрвөн цаг” зэрэг дуундаа байгалийн сайхныг илэрхийлсэн байна.

Энэ бүхэн нь байгалиа танин ухаарсан, ахуй амьдралаас нь урган гарсан гоо сайхны сэтгэлгээнийх нь илрэл байхын сацуу энвайронменталь гоо зүйн үүднээс уламжлалт сэтгэлгээн дэх байгалийг гоо зүйн мэдлэгийн объект гэж үздэг, сүрлэг, сэтгэл татам гэдэг ойлголтуудыг шингээсэн нь илт байна. Судлаач Х.Нямбуу бичихдээ “Монголын ард түмэн түүхэндээ дэлхийн бусад иргэний нэгэн адил урлаг, гоо сайхны өвөрмөц соёлыг бүтээн, гоо зүйн сэтгэлгээний үндэсний уламжлалыг үүсгэн хөгжүүлж ирсэн”¹¹ гээд монголын гоо зүйн сэтгэлгээний өв уламжлалыг танин мэдэхэд тэдний гоо сайхны төсөөлөл үнэт эх сурвалж гэж үзээд тэрхүү төсөөлөлд монгол орны байгалийн байдал, уул ус, ургамал амьтан, од гариг хийгээд малчин хүний адгуулах таван хошуу мал, соёл аж байдлын зүйлс болон хүний тухай гоо сайхны ойлголт багтаж байна хэмээсэн байдаг. Нөгөө талаас энвайронменталь гоо зүйн утгаар, байгаль бол таашаалын объект байж түүнийгээ урлагийн бүтээл болгон илэрхийлж буй хэрэг юм.

Хүний ухамсар оюун санаа хөгжиж боловсрохын хэрээр хүн байгаль орчиндоо дасан зохицож, амьдрах арга чадвараа сайжруулахын зэрэгцээ хүрээлэн буй байгаль эх дэлхийгээ алхам алхмаар танин мэдэх болсон байна. Хүн байгаль ертөнцөө танин мэдэхийн сацуу өөрт хамаарах бүхэл бүтэн оюуны ертөнц ахуйг бүтээсэн байдаг. Иймд байгаль бол танин мэдэхүйн үлэмж том талбар бөгөөд материаллаг баялагийг бидэнд өгөхөөс гадна хүний

⁹ Монгол зан үйлийн нэвтэрхий толь. Оюуны боть. УБ., 2021, 1132 дахь тал.

¹⁰ Монголын зан үйлийн нэвтэрхий толь. Оюуны боть. УБ., 2021, 1133 дахь тал.

¹¹ Х.Нямбуу. Монголчуудын гоо зүйн сэтгэлгээний өв уламжлалаас. Философи эрхийн судлал I. УБ., 1977. 103 дахь тал.

оюуны соёл төлөвшин хөгжих эх ундаргын нэг хэмээн үзэж болно. Байгалиа танин мэдэх, шинжих, түүний ааш аягт зохируулан амьдрал ахуйгаа хөтлөн явуулж ирсэн монголчуудын байгалийг авч үзэх сэтгэлгээний гол онцлог нь байгалийн сайхныг мэдрэх, олж харах, магтан дуулах, шүтэн бишрэх цаашилбал хайрлан хамгаалах арга ухаанд холбогддог. Ийм сэтгэлгээний нэг илрэл бол монголчуудын байгаль шинжих ёс бөгөөд үүгээрээ байгалийн зүйл бүрийн үзэгдлийг ажиглан, шинжин таньж, ахуй амьдралаа түүндээ зохицуулж ирсэн явдал юм. Үүнд нар, сар хэрхэн мандаж жаргах, салхи салхилах, үүл нүүх, од мичидийн хөдөлгөөн, амьтад яаж ичих, ургамал ногоо, цэцэгс хэрхэн хагдарч, дэлгэрэх, манан буух, солонго татах, аянга цахилгаан яаж цахих, эрвээхэй, болжмор, могой, шоргоолж гээд энэ амьдралд зэрэгцэн оршиж байгаа бүхий л зүйлээ гярхай ажиглан амьдрал ахуй, үйл хөдлөлөө тэр бүхэнтэй зохируулан амьдарч ирсэн соёлтой. Тийм соёл, зан заншлууд ч олноор бий. Хамгийн наанадаж, шувууны өндөгөнд сүүдрээ тусгадаггүй байсан эрхэм заншил эрт үеэс уламжлагдсаныг мэднэ. “Бидэнд ёс заншлын, цээр хорионы, сургаал сургамжийн арвин их өв бий. ...Монголд таван мянга орчим ийм хорио цээр тогтоож байсан гэж үздэг бөгөөд тэдгээрээс олонхи нь одоо ч ач холбогдлоо алдаагүй хэвээр байна”¹² хэмээн судлаач М.Гантуяа, Б.Гантөмөр нар бичсэн нь бий.

Судлаач Ж.Долгорсүрэн, нүүдэлчин монголчуудын бүтээсэн ёс заншил, зан үйлийн соёл нь хүн байгалийн нарийнх арилцан шүтэлцээг гойд тусгаж чадсанаараа онцлог, мөн тэнгэр хангай, байгалийн юмс үзэгдэл (нар сар, од эрхэсийн хөдөлгөөн, өвс ургамалын гарц, малын хэвтэр) өөрийн биеийн ажиглан мэдэрч, өдөр сар болон жилийн өнгийг урьдчилан мэддэг өндөр соёлтой байсан нь байгальтай ойр ахуйтай нь холбоотой байна

¹² Философи, эрх зүйн боловсрол. УБ., 2014. №7. 14 дэх тал

гэж үзээд нүүдэлчин монголчуудын соёл бол байгалиас шууд эрчим авч хүчижсэн байгалийн хүмүүний бүтээл, түүний үр дүнгийн тогтолцоо мөн¹³ гэсэн байдаг. Эндээс харахад монголчуудын байгалийг ийнхүү хүндэтгэж, шүтэж ирсэн үнэлэмж бол угтаа нүүдэлчин ахуйтай шууд холбоотой, тодруулбал байгалийн зан авирт тохируулан ахуй амьдралаа хөтлөн явуулдаг байсан хэрэглээ, хэрэгцээнд тулгуурлаж бий болсон хэрэг юм. Энвайронменталист гоо зүйн үзэл дэх байгальд ойр байж, түүнтэй харилцах явцдаа хамгаалах, нөөцлөх, түүнийгээ амьтай хэмээн үзэж хүндэтгэх үзэл санаа энэхүү уламжлалт сэтгэлгээнд бүрэн дүүрэн агуулагдаж байна.

Байгалийн гоо сайхны үнэлэмж ба экологи: Постгуманист философич Франческо Феррандогийн хэлснээр “Хүн бол гараг ертөнцтэй амин чухал харилцаатай, бидний метаболизмыг тэтгэгч хүнс, хүчилтөрөгч агуулсан агаар мандал гэх мэт, үүнгүйгээр хүн амьд оршин тогтнож чадахгүй”¹⁴ ажээ. Иймээс хүн төрөлхтөн байгалтай уялдаа холбоотой нь өөрийнх нь оршихуйтай нягт холбоотой учир хүний үнэлэмж, мэдрэмжийн онцгой баримт болж байна.

Монголчуудын гоо сайхны сэтгэлгээний хэлбэр нь түүнийг шүтэх, хайрлах, тэнцвэрт байдлыг нь хадгалах, байгальтайгаа шүтэлцэн амьдрах байдлаар илэрдэг гэдгийг өмнөтөө дурдсан. Амьдралынхаа туршид зуны дэлгэр, намрын налгар, өвлийн цэнгэг, хаврын хайлган цагаар байгалийн сайханд тэмүүлж, байгалиас эрч хүчээ авч улирал, цаг агаарт нийцүүлэн амьдрал ахуйгаа зохицуулж, төлөвлөж, үйлдэж байдаг. Харин үүний зэрэгцээ байгалийн гоо сайхныг хэвээр үлдээх, хадгалах тал дээр анхаарах шаардлага жилээс жилд нэмэгдэж байгаа нь энвайронменталь гоо зүйн онолыг судлах, үзэл са

¹³ Ж.Долгорсүрэн. Аман соёлын арга билгийн шүтэлцээ. УБ., 2000. 65-66 дахь тал.

хэрэгжүүлэх хэрэгцээг харуулж байна. Шинэ цагийн судлаачид, уран бүтээлчид,

зохиолчид ч мөн байга лийн тухай, түүний гоо сайхны тухай бахдан дүрсэлж, шүлэг яруу найраг, урлагийн төрлүүдэд илэрхийлсэн байдаг. Гэхдээ уламжлалт гоо зүйн үзэл дэх байгалийн сайхныг репрезентационизмын үүднээс авч үздэгээс илүүтэй, анхааруулсан, сэрэмжлүүлсэн олон янз байдлаар бичих болсон нь дээр өгүүлсэн энвайронменталь гоо зүйн үзэл баримтлалд ойр агуулгатай болсон. Тухайлбал яруу найрагч, зохиолч Г.Мэнд-Ооёогийн Хээр талаас бичсэн захидлууд, сэтгүүлч Б.Галааридын Шар тэнгисийн тарчлаан жүжиг зэрэг сүүлийн үеийн уран бүтээлч, туурвигчдын бүтээлүүдээс байгалийн сайхны тухай төдийгүй түүнийг хамгаалахад уриалан дуудсан санаануудыг анзаарч болох билээ. Монголын уран бүтээлчид, зохиолчдын бүтээл туурвилд тусгагдсан байгаль, хүрээлэн буй орчны гоо зүйн тухай санаа шүлэг, яруу найраг, дуу хөгжмөөр зогсохгүй урлагийн бүхий л төрөлд агуулагдаж байдаг бөгөөд эл өгүүлэлд сүүлийн үеийн онцлох заримыг нэрлэлээ.

Энэ бүхнээс нэгтгэн үзвэл энвайронменталь гоо зүйн үзэл баримтлал үнэлэмжийн болон байгалийг хамгаалах ёс зүйн үзэл санаанд уялдаж байгаа юм. Сүүлийн үед хүрээлэн буй орчны гоо зүй, хүрээлэн буй орчны ёс зүйн мэдлэгийн уулзварт бий болсон экоэстетик гэсэн шинэ салбар бий болсныг судлаачид өгүүлж байна. Эдгээр нь хүний гараар бүтээгдсэн

болон хүний нөлөөлөлд өртсөн хүрээлэн буй орчныг авч үзсэн өргөн хүрээг хамран

¹⁵ Tobias Brosch, David Sander. Handbook of value. 2016. p.343

¹⁶ Энэ тухайд анхаарал хандуулахаар 2019 онд МУИС, ШУА-ийн Философийн Хүрээлэн, ШУТИС, Монголын Философийн холбоо, Номын Гурван Хүрдэн сан хамтран “Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан юм. Эл хурлын эмхтгэлийн өмнөтгөлд “Ногоон ёс зүй хэмээх нэр томъёо нь байгаль хамгаалах, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дэлгэрүүлэхэд хэрэглэж буй нэг ойлголт бөгөөд энэ үзлийн чиг хандлага нь байгальтай зохицон амьдрах, байгаль орчноо хайрлан хамгаалж, сайжруулах, эрүүл аж төрөх үйлд суралцах зэрэг өргөн утгыг агуулж байна” хэмээн онцолсон байна. Мөн “монголчууд байгалийг оршихуйн суурь хэмээн үзэж, түүнтэй харилцах баялаг туршлагаараа бусдад үлгэрлэхүйц түүхтэй боловч энэ цаг үед бид бусдын сайн бодлого, туршлагыг судлахын зэрэгцээ байгальтайгаа зохицон амьдрахуйн зайлшгүйг ухаарч амьдарч ирсэн өөрсдийн уламжлалт сургаалаас судалж, суралцах, сурталчлахыг мөн чухалд тооцох нь зүйн хэрэг” гэдгийг ч мөн дурдсан байна. Доктор Ч.Баярчимэг, М.Золзаяа, Д.Оюунгэрэл нар “Монголчуудын амьтныг хамгаалах ёс суртахууны уламжлал ба орчин үе” бүтээлдээ “байгаль орчинтой харьцах уламжлал нь хүрээлэн буй орчноо хамгаалах сэтгэлгээг хувь хүнд төлөвшүүлэх хүмүүжлийн өвөрмөц онцлог бүхий

судалдаг аж.

“Байгалийн тухай үнэлэмжийн тухайд, ёс суртахууны үнэлэмж байгаль орчны талаархи хүний зан үйлийн чухал хөдөлгөгч хүч байдаг ч гоо зүйн үнэлэмж нь магадгүй бүр ч чухал юм.

“Сүүлийн хориод жилд хүрээлэн буй орчны үнэлэмж шийдвэр гаргалтад нөлөөлөхийн сацуу зан төлөвт ч бас ач холбогдолтойгоор нөлөөлөх байдал нэмэгдэж байна”¹⁵ гэж судлаачид үзэх болжээ. Хүрээлэн буй орчноо хадгалж, хамгаалж, эх байгальтайгаа зохицон амьдрахгүй бол хордсон байгальтай, өвчилсөн хүн амтай, эдийн засаг, улс төр, хөгжил хэнд хэрэгтэй вэ гэдэг асуудал гарч ирсэн.¹⁶

Тэгэхээр энэхүү өгүүлэл дэх үндсэн санааг бид дараахь байдлаар дүгнэж байна. Юуны түрүүнд философи мэдлэгийн төрөл болох гоо зүй нь сайхны болоод ёс зүйн өргөн агуулгыг тээх бөгөөд үүгээр дамжуулан байгалийн талаарх ойлголтыг тайлбарлахад орчин үеийн утгаар нэн ач холбогдолтой байна. Ялангуяа монголчуудын соёл, нүүдэлчин ахуйгаас үүдэлтэй байгалийг таашаах, хайрлах, бишрэх сэтгэлгээ нь гоо зүйн үнэлэмж болохоос гадна байгальдаа зохицон амьдрах, аж төрлөө нийцүүлэн авч явах практик хэрэгцээтэй нь шууд холбоотой бий болсон. Улмаар энэ үзэл хандлага нь хүрээлэн буй орчны буюу экологийн шийдвэр гаргалтад чухал нөлөөтэй, ёс зүйн хувьд үндсэн баримжаа нь болж байдгийг харуулж байна. Эдүгээ уур амьсгалын өөрчлөлт, байгалийн

арга болон бидэнд уламжлагдан ирсэн нь өнөө цагийн экологийн боловсрол, хүмүүжил олгох үйл бөгөөд төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын залгамж чанарын нэг хэсэг” хэмээн бичжээ.

баялгийг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлого, байгалийг нөхөн сэргээх зэрэг үйл ажиллагаатай холбоотойгоор байгалийн талаарх сэтгэлгээ, үнэлэмж ихэд өөрчлөгдөх болсон бөгөөд энэ талаар цаашид судалгаа явуулах, бүтээл туурвил хийх, нийгмийн үрнөлөөг тооцох, нэмэгдүүлэх ажлууд зохионбайгуулах нь зүйн хэрэг юм.

Орчин үед эл соёл, үнэлэмжийг дэлхий нийтийн сэтгэлгээ, үнэлэмжид харьцуулан судалж, байгальд хандах шинэ үнэлэмж, ёс суртахууны хандлага бий болгоход энвайронменталь гоо зүйн үнэлэмжийн судалгааг шинэ цонхоор харах нь чухал ач холбогдолтой болохыг онцолж байна.

Ном зүй

Монгол хэл дээр

1. Ч.Баярчимэг, М.Золзаяа, Д. Оюунгэрэл. Монголчуудын амьтныг хамгаалах ёс суртахууны уламжлал ба орчин үе. УБ., 2020
2. Д.Болд-Эрдэнэ. Улс төрийн философи. УБ., 2015
3. Ж.Долгорсүрэн. Аман соёлын аргабилгийн шүтэлцээ. УБ., 2000
4. Монголын философийн түүх. Идэвтэр. УБ., 1997
5. Монголын зан үйлийн нэвтэрхийтоль. Оюуны боть. УБ., 2021
6. Н.Сарантуяа. Монголын нүүдэлчний иргэншил, соёл, уран сайхны соёл. УБ., 2010
7. Тогтвортой хөгжил: Ногоон ёс зүй. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2019
8. Ж.Төмөрбаатар. Монголын ард түмний гоо сайхны сэтгэлгээний түүхийн асуудал. УБ., 1990
9. Философи эрхийн судлал I. УБ., 1977
10. Философи, эрх зүйн боловсрол. УБ., 2014. №7

Англи хэл дээр

1. J. Baird Callicot, Robert Frodeman. Encyclopedia of environmental ethics and philosophy. 2009
2. Francesca Ferrando. Philosophical Posthumanism. 2019
3. Jerrold Levinson. The Oxford Handbook of Aesthetics (Oxford Handbooks Series). 2005
4. R. Rozzi et al. (eds.), Linking Ecology and Ethics for a Changing World: Values, Philosophy, and Action. 2013
5. Tobias Brosch, David Sander. Handbook of value. 2016.
6. Barry Hartley Slater. 'Aesthetics', The Internet Encyclopedia of Philosophy. <http://www.iep.utm.edu> (2006)
7. Theodor Adorno, Aesthetic Theory. 2002

***Abstract:** The authors aimed to elucidate the aesthetical thinking of nature and its ecological significance. Aesthetics is how people interact with and express things that exist. Mongolians have a long tradition of caring for nature. Our tradition is not only an aesthetic value but also has a significant impact on environmental protection and ecological policies. Our tradition is not only aesthetically valuable but also has a substantial effect on protecting the environment and managing natural resources wisely. This article discusses the peculiarities of Mongolian life, the traditions of how they treated nature, and the concept and value of natural beauty reflected in their knowledge. As we know, values carry a wide range of aesthetic and ethical contexts and are essential in explaining the idea of nature. In particular, the Mongolian culture and nomadic way of loving and admiring nature are aesthetically pleasing. It is an expression of values and is directly related to the practical need to live in harmony with nature and is a vital guide to environmental decision-making.*